

Сүүлийн жилүүдэд бага насны хүүхдийн харааны гажгийн өөрчлөлт Монголд төдийгүй дэлхийн олон оронд анхаарал татсан асуудал болжээ. Тиймээс Монголын нүдний эмч, хараазүйчид Азийн эмч нарын холбоо буюу "AMDA"-гийн гүйцэтгэх захирал Тае Намба, Японы хараа зүйчдийн нийгэмлэгийн мэргэжлийн зөвлөх Учида Цуёши нарыг урьж ирүүлсэн байна. Монголын улсын болон хувийн эмнэлгийн нүдний эмч, хараазүйчид, нүдний шилний ажилчид гээд 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй эл арга арга хэмжээний



Хүүхдийн харааг гурван наснаас эхэлж хянуулаарай

үеэр хүүхдийн харааг хэрхэн хамгаалж болдгийг сонирхлоо. Ер нь нүдний хараа муудах нь өвчин биш гэнэ. Тиймээс хараанд өөрчлөлт орлоо ч тэгтлээ шаналах хэрэггүй ч зөнд нь орхиж болохгүйг эмч мэргэжилтнүүд санууллаа. Тиймээс хараа муудсан л бол зохих хугацаанд эмчлүүлж, эмчийн хяналтад байх хэрэгтэй гэв. Харин хугацаа алдах тусам хараа тогтворгүйжиж, эдгэшгүй өвчин болох магадлал өндөртэй юм байна. Хараа муудах нь хэд хэдэн шалтгаантай. Үүний нэг нь нүдний хэлбэр өөрчлөгдөж, түүнийг зохицуулах механизм алдагдсантай холбоотой аж. Нөгөөтэйгүүр хараа муудах нь удамшилтай ч холбоотой гэх. Эсвэл түр зуурын хараа муудалт байж болдог гэнэ. Тиймээс энэ бүрт нүдний эмч, хараазүйчид зөв оношилж, шаардлагатай шилийг нь зүүлгэх ёстой. Зүүлгээгүй тохиолдолд хараа огцом мууддаг аж.

Харамсалтай нь манайд сүүлийн жилүүдэд мэргэжлийн бус хүмүүс шил тааруулах бизнес эрхлэх нь ихэссэн. Энэ нь харааны гажгийн өөрчлөлттэй хүмүүсийн тоо нэмэгдэхэд нөлөөлж байгааг ч хэлнэ лээ.

Тиймээс ойрын хугацаанд Азийн эмч нарын холбоо буюу "AMDA", "Cityoptic" компанитай хамтран Монголд хараазүйн сургууль байгуулахаар төлөвлөж байгаагаа энэ үеэр хэлсэн.

Хүүхдийг төрснийх нь дараа нүдний үзлэгт хамруулж, ургийн гажигтай эсэхийг нь шалгуулж, зохих арга хэмжээ авах шаардлагатай гэнэ. Энэ нь олон улсын жишиг ч манайхан тэр бүр мөрддөггүй юм байна.

Ядаж хүүхдийг 3-5 насанд нь харааны үзлэгт хамруулж, хараа муутай бол зохих эмчилгээ хийлгэх



"AMDA"-гийн гүйцэтгэх захирал Тае Намба

дэхүүн юм байна. Гол нь контакт линз нь хүний нүдэнд харагддаггүй хугарлын гажигуудыг шилнээс илүү засдагаараа давуу аж. Гэхдээ чанартай линзийг зориулалтын дагуу зүүхгүй бол эргээд нүдний эвэрлэг бүрхүүлийг гэмтээх аюултай. Мөн хараагүй ч болох магадлалтай учир сайн чанарын линзийг зохих газраас нь авч зүүхдээ мэргэжлийн эмч, хараазүйчдээс зөвлөгөө авах хэрэгтэйг сануулав.

Нийслэлд зохиогдож буй Монгол, Япон эмч нарын хурлын арга хэмжээний хүрээнд хүүхдийн харааг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ зохиогджээ. Үүний нэг нь амьдралын боломж тааруу айлын хараа муутай хүүхдэд шил тааруулах арга хэмжээ байж. Энэ хүрээнд 30 гаруй хүүхдэд "Cityoptic" төв харааны шил тааруулж өгчээ. Хүүхдүүдэд шил тааруулахад зарцуулагдсан энэ мөнгийг Японы Окаяма хотын "Ёшида" бага сургуулийн сурагчид хандивлажээ. Ийн

Тэр дундаа нүдний өвчлөл, харааны тал дээр анхаарах шаардлагатайг Монголын талаас "Cityoptic" төвийн хараазүйч Ч.Эрдэнэбат санал болгосон. Ингээд "AMDA"-гийн ерөнхийлөгч Монголын хүүхдүүдэд туслахаар шийдсэн хэрэг.

Угаас хүүхдийн өвчлөлийн дотор харааны сулрал нүдний өвчинд анхаарах шаардлагатай хэмээн "AMDA" үздэг. Гол нь Монголын нүдний эмч, хараазүйчдийн идэвхи, хүчин чармайлт энэ удаагийн арга хэмжээг зохион байгуулахад нөлөөлснийг онцлох хэрэгтэй байх. "AMDA"-гийн Монгол руу чиглэсэн арга хэмжээ үүгээр зогсохгүй. Монголын нүдний эмч нар болоод хараазүйчид Японы хараазүйн томоохон эрдэмтэдтэй уулзаж харилцаа тогтоосон байгаа. Бид цаашид ч дэмжиж, хамтарч ажиллах болно" гэв.

Мөн Японы хараа зүйчдийн нийгэмлэгийн мэргэжлийн зөвлөх Учида Цуёши хүүхдийн харааг хамгаалах талаар зөвлөгөө өгсөн юм. Түүний хэлж буйгаар хүүхэд багаасаа эхэлж хараандаа тохирсон шил зүүх хэрэгтэй гэлээ. Эс тэгвэл аажим аажмаар хүүхдийн хараа сулрахаас гадна харааны гажигтай болох эрсдэлтэй аж. Дэлхийн аль ч оронд хүүхэд залуучууд гар утас, компьютер, PC тоглоомыг өдөр тутамд хэрэглэдэг болсноо үүдэн сүүлийн жилүүдэд энэ сэдэв сөхөгдөж болсон. Тиймээс хүүхдийн харааны сулрал Монголд төдийгүй Японд ч том асуудал болж байгаа гэлээ.

Хараа нь суларсан ч нүдний шил зүүхгүй байх тусам тухайн хүний хараа мууддаг байна. Хоёр орны нүдний эмч, хараазүйчдийн чуулганы хүрээнд тэд хараазүйн "Cityoptic" төв дээр ажиллажээ. Энэ үеэр тухайн төвд ирж хараагаа шалгуулагдсдын дийлэнх нь хүүхэд залуус байсан. Тэднийг шинэ шил зүүж, хараагаа сэргээх арга хэмжээний талаар мэдээлжээ.